

ГАМШГААС ХАМГААЛАХ САЛБАР ДУНДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Ж.ДАМБАДАРЖАА

ОБЕГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газрын
дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн,
хошууч, удирдахуйн ухааны магистр.

Хураангуй

Гамшгаас хамгаалах салбар дундын удирдлагын онол арга зүйн асуудал, олон улсын туршлага, гамшгаас хамгаалах салбар дундын удирдлагын үйл ажиллагааны байдлыг сайжруулах боломжийг судалсан. Гамшгаас хамгаалах салбар дундын үйл ажиллагааны удирдлага зохицуулалт, тэдгээрийн ажлын уялдаа холбоо ажлын үрлийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлсон судалгааны бичгээр дүгнэж байна. Үйл ажиллагааны байдлаар гамшгаас хамгаалах салбар дундын үйл ажиллагааны удирдлага нэгдсэн нэг удирдлагад орж чадаагүй, хоорондын уялдаа холбоо сул байгаа зэргээс түүнийг улам боловсронгуй болгох шаардлага олон жилийн гамшигтай тэмцэх үйл ажиллагааны туршлагаас урган гарч байна. Иймд гамшгаас хамгаалах салбар дундын үйл ажиллагааны удирдлага зохицуулалт, ажил үрлийн онцлогт шинжилгээ хийж, цаашдын үйл ажиллагааг сайжруулах боломжийг судлан үйл ажиллагааны дүгнэлт, саналаа илэрхийллээ.

Төвлөрөгч: гамшиг, аюулт үзэгдэл, гамшгаас хамгаалах удирдлага, гамшигын дараах үйл ажиллагаа

Судалгааны ажлын үндэслэл:

Манай улсын хэмжээнд 2021 оны 12 сарын байдлаар 3,852 удаагийн аюулт үзэгдэл, ослын тохиолдол бүртгэгдэж, гамшигын улмаас 3,559 хүүхэд нас барж, нийт 108.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан. Үйл ажиллагааны мөнх оны мөнх үетэй харьцуулахад гамшиг, аюулт үзэгдэл, ослын тоо 8.2 хувиар өссөн байна.

Малын гоц халдварт шалхий үеийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ны байдлаар 20 аймгийн 197 сумд 374 голомт бүх аймагт тархаад байна.

Сүүлийн жилүүдэд үйл ажиллагааг үйл ажиллагаагийн шинэ төрлийн үеийн үйл ажиллагаа бий болж, гамшиг, ослын аюул занал шинэ төрөл, хэлбэрээр өссөх нь бий боллоо. Тухайлбал, манай оронд 2022 оны 01 дүгээр сарын 20-ны үйл ажиллагаагийн байдлаар цар тахлын тархалтын тоо 415.7 мянган болж, 2016 хүүхэд нас барсан нь 1939 оны Халхын голын дайнд амь алдсан хүүхдийн тооноос бараг 4 дахин илүү байна. Цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ авч явуулах нь нэг улсын бус дэлхий нийтийн болон улс орнуудын харилцан ажиллагааг сайжруулах шаардлага гарч байна. “Covid-19” цар тахалтай тэмцэх ажил нь манай улсын дан ганц УОК, ОБЕГ, ЭМЯ-ны ажил биш нийт гамшгаас хамгаалах Улсын албад, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа, салбар дундын удирдлага зохицуулалтаас харагдаж байна.

Сэдвийн судлагдсан байдал:

Орчин үеийн менежментийн онол, загвар, үзэл баримтлалыг олон эрдэмтэд судалж тодорхойлсон байна. Тухайлбал, Питер Ф.Друкер “XXI зууны менежментийн үзэл баримтлал”, П.Сенго “Суралцагч байгууллагын онол”, Броун, Крейс “Менежментийн загвар” гэсэн сэдвээр судалгаа хийж менежментийн судалгаанд үнэтэй хувь нэмрээ оруулжээ.

Монгол Улсад 1980-аад оноос байгууллагын менежментийн талаар диссертацийн түвшинд судалгаа нэлээд хийгдсэн байна. Тухайлбал, Т.Дорж, Д.Цэрэндорж, Ц.Цэрэндорж, Ц.Цэцэгмаа, Ц.Самбалхандэв, Н.Нарантуяа, нарын олон эрдэмтэн судлаачид байгууллагын хөгжил, хөгжлийн үйл ажиллагаа, менежментийн чиглэлээр олон тооны бичгээр, ном, сурах бичиг бичиж гаргасан байна. Доктор, профессор, Ц.Цэрэндорж нь “Бидний менежмент”⁶⁸ бичгээр менежментийн онолын үндэс, шинэ зууны менежментийн

⁶⁸ Цэрэндорж Ц, “Бидний менежмент”, УБ., 2010,

парадигма, орчин үеийн байгууллагын менежмент, үнэ цэгийн тулгамдсан асуудлын талаар тодорхой авч үзжээ.

Гамшгаас хамгаалах үеийн удирдлага зохицуулалтын ажиллагааг сайжруулах арга замын асуудлыг доктор, профессор Маршалл Сильвер⁶⁹ Монгол Улсын гамшгийн удирдлагын шинэчлэлтийн явцад үүх нэлгээ, цаашид анхаарах зарим асуудлын талаар авч үзэхдээ “Монгол орон шиг гамшигт өртөмтгий улс гамшгийн удирдлагыг агентлагийн хэмжээнд тавих юм бол тухайн агентлагийг харьяалалдаа багтаасан яамны сайд гамшиг тохиолдсон үед бусад үйл ажиллагаа явуулах цаг, боломжгүй болно” гээд “Гамшигтай тэмцэх комисс байгуулж, гамшгаас хамгаалах улсын албадын дарга нар буюу Засгийн газрын гишүүдийг нэгтгэж байгаа нь чухал үр дүнтэй болсон байна” гэжээ.

Судлаач Ник Картер⁷⁰ нь гамшгийн менежментийн үндэсний бодлого, удирдлага зохицуулалтын талаар авч үзсэн бол, судлаач Жон Твиг⁷¹ нь гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, гамшгийн аюул, эрсдэлийг бууруулахад нөлүүлж буй хүчин зүйлүүдийн тухай олон туршлагыг судалж, Тамшгийн эрсдэлийг бууруулах туршлага, түүхэн сургамж” номыг бичжээ. Английн Кранфилдийн Гамшгийн удирдлага, зохицуулалтын төвийн судлаач Майк Эванс⁷², Мэрвин Жонс нар гамшгаас хамгаалах удирдлагын гурван төвшний удирдлагыг тодорхойлсон байна. Гамшгаас хамгаалах удирдлагын онол, салбар дундын зохицуулалтыг хангаж буй туршлагыг судалсан үр дүн:

Гамшгаас хамгаалах удирдлагын ойлголт, мөн чанарын тухай авч үзэхдээ юуны мөн удирдлага гэсэн ойлголтыг авч үзэх нь зүйтэй билээ.

Аливаа шинжлэх ухаан үүрийн судалгааг тулгуурладаг үндсэн гол ойлголттой байдаг. Зохион байгуулалт болон удирдлагын салбарын тэргүүний онолч, менежментийн эцэг гэж нэрлэгдэх болсон Питер Ф.Друкер удирдлагыг “Удирдлага гэдэг нь зохион байгуулалтгүй бөөгнөрсөн хүмүүсийг үр ашигтай, бэтээмжтэй бөлөг болгон өрчлөх үйл ажиллагааны онцгой хэлбэр юм” гэж тодорхойлжээ. Удирдлага бол байгууллагын зорилтуудыг томьёолж түүнд хүрэхийн тулд зайлшгүй төлөвлөх, зохион байгуулах, идэвхжүүлэх, хянах үйл явц юм гэж үзэж болно. Удирдлага болон менежмент ойролцоо утгатай үг боловч тус тусдаа бие даасан ойлголт юм.

Монголын Менежментийн холбооны ерөнхийлөгч, доктор (Sc.D) профессор Ц.Цэрэндорж “Удирдлага гэдэг бол шууд утгаараа дээрээс доош чиглэсэн зааж зааварлах, хянаж шалгах тогтолцоо юм. Гэтэл заримдаа үүнийг менежмент гэж ойлгоод байгаа нь буруу юм. Өөрөөр хэлбэл менежмент нь үүнээс арай өргөн хүрээтэй ойлголт⁷³” гэжээ.

Францын эрдэмтэн А.Файоль менежмент нь төлөвлөх, зохион байгуулах, захирах, зохицуулах, хянах гэсэн таван үүрэгтэй гэж үзжээ.

Менежмент гэдэг нь байгууллагын зорилгод хүрэхийн тулд нөөцүүдийг үр ашигтай, үр дүнтэй арга замаар төлөвлөж шийдвэр гаргах, зохион байгуулах, манлайлах, хянах үйл ажиллагаануудын нэгдэл мөн. Менежмент бол аливаа байгууллагын мөн тавигдсан зорилт хэрэгжүүлэх зарчим, арга барилыг багтаасан цогц асуудал юм.

Менежментийн шинжлэх ухааны судлах зүйлийн үндэс нь байгууллага байдаг.

Байгууллага гэдэг нь нэг ерөнхий зорилгод хүрэхийн төлөө нэгдсэн хүмүүс тэдгээрийн ухамсарт үйл ажиллагааны нэгдэл байдаг. Чухамдаа хүн төрлийн үйл ажиллагааны иж бүрэн нэгдлийг л байгууллага гэж олонх судлаачид үзэж байна.

Байгууллага гэдэг нь мөн тавьсан тодорхой зорилгод хүрэхийн төлөө үйл ажиллагаагаа ухамсартайгаар зохицуулж байгаа бөлөг хүмүүс юм. Энэ тодорхойлолт нь албан ёсны байгууллагад хамаарах ба үүний зэрэгцээ албан ёсны бус байгууллага гэж байдаг.

Гамшгаас хамгаалах удирдлага нь гамшгийн мөнх, гамшгийн үеийн, гамшгийн

⁶⁹ НБ-ын Гамшгийн удирдлагын эксперт Тамшгаас хамгаалах менежментийн асуудлууд, УБ., 2001 судалгааны тайлан, Монгол Улсын гамшгийн удирдлагын шинэчлэлт” үндэсний бага хурал, УБ., 2004, 31 дэх тал,

⁷⁰ Авсрали улсын иргэн Нисэх хүчний дэд маршалл, тэрээр гамшгийн менежментийн талаар 50 гаруй бичээл бичсэн, Тамшгийн менежмент” номыг 1990 онд зохиосон.


⁷¹ Англи Улсын иргэн, судлаач нь Тамшгийн эрсдэлийг бууруулах туршлага, түүхэн сургамж”

⁷² Английн Кранфилдийн Гамшгийн удирдлага, зохицуулалтын төвийн судлаач Майк Эванс нь Гамшгийн удирдлага зохицуулалтаар ОБЕГ-т сургалтыг 1999 онд явуулсан байна.

⁷³ <https://gogo.mn/r/4gvxk>

дараах гэсэн гурван шаттайгаар хэрэгжинэ.

Зураг 1. Гамшгаас хамгаалах удирдлага



П.Цэдэв, Гамшгаас хамгаалах төлөвлөлт, УБ., 2018, 80 тал

Гамшгийн өмнөх удирдлага: Гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтын хэрэгэнд гамшгийн өмнөх шатанд гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах нь гамшгаас урьдчилан сэргийлэх шат арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Гамшгийн өийн удирдлага: Гамшгийн өе шатанд нэрвэгдэгсдийг эрэн хайх-аврах, яаралтай тусламж үзүүлэх, хор уршгийг арилгах чухал арга хэмжээнүүдийг авч явуулна. Гамшгийн үед өөсч бий болсон нөхцөл байдлыг богино хугацаанд нэлэн шийдвэр гаргаж хич хэрэгслээ зохистой хуваарилан аврах, эрэн хайх үйл ажиллагаа явуулна. Энэ үед дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт зэрэг улс орныг хамарсан томоохон ажлууд хийгдэхээс гадна нэрвэгдэгсдэд хмүүлэгийн тусламж үзүүлэх, өндсэн дэд бүтцийг яаралтай сэргээн босгох, хохирлын өнөлгээ хийх зэрэг гамшгийн дараа хийвэл зохих ажлууд хийгдэж эхэлнэ. өндсэндээ аврах ажиллагааны өийн удирдлага явагдана.

Гамшгийн дараах удирдлага: Гамшгийн дараах өе шатанд хойшлуулшгүй сэргээн засварлах ба сэргээн босгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Гамшгийн дараа нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, гамшигт өртсөн дэд бүтэц, объектуудыг сэргээн босгох, гамшигт нэрвэгдсэн байгууллага, аж ахуйн нэгж, хмүүлсийн үйл ажиллагааг сэргээн хэвийн байдалд оруулах өр их ажил өрндөг.

Энэ удирдлагын өед нэрвэгдэгсдэд хмүүлэгийн тусламж үзүүлэх, хохирлын өнөлгээг нарийвчлан хийх, хор уршгийг өрөн арилгах, сэргээн босгох, сэргээн засварлах, тэсвэрлэх чадавх болон бат бөх чанарыг нэмэгдүүлэх гэх мэт маш олон арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах салбар дундын удирдлага зохион байгуулалтаар хор уршгийг арилгах хойшлуулшгүй чухал үйл ажиллагаа явагдаж байдаг.

Канадын Улсын эрдэмтэн Ж.Сканлон "Миний судалсан бөх гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаа өөрт давтагдан гарч байсан бэрхшээлтэй асуудал бол гамшгийн зохицуулалт байв" гэж тодорхойлжээ. өнэхээр гамшгийн удирдлага зохицуулалт нь хор уршгийг арилгах ажиллагааны өрдөнг тодорхойлохуйц чухал асуудал юм.

Олон улсын туршлагаас үзэхэд дараах дүгнэлтүүд гарч байна. өөнд:

ОХУ-ын Онц байдлын яам нь ерөнхий чиг өөргийн байх ба сайдын ажлын алба, төвийн болон орон нутгийн газар хэлтсээс өөрддэг байна. Тус яам нь цэрэгжүүлсэн статустай, төрийн тусгай албан хаагчдын өөрэлдхөөнтэй байна. ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2005 онд зарлигаар "ОХУ-д тохиолдсон гамшгийн өед төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг зохицуулах харилцан ажиллагаа" гэсэн удирдлагын баримт бичиг гаргасан байна.

Олон улсын туршлагаас харахад Япон, Хятад зэрэг улс орнууд гамшгаас хамгаалах арга хэмжээг тухайн улсын хөгжлийн төлөвлөлтөд нарийвчлан тусгаж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослын өед хөний эрх, эрх чөлөөг дээдлэх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан төлөвлөгдсөн, шуурхай, уян хатан, тасралтгүй байх, хязгаарлагдмал нөхцлийг өрдөнтэй ашиглах, гэсэн арга хэмжээнүүдийг тусган

“удирдлага зохион байгуулалт”, “гамшгаас урьдчилан сэргийлэх”, “аврах”, “хор уршгийг арилгах”, “сэргээн босгох ажиллагаа” гэсэн 16 шатаар төлөвлөн, харилцан ажиллагааг давхар тооцон боловсруулдаг байна.

Канад Улс: Энэ улсад иргэний хамгаалалтын байгууллага нь 1ндэсний батлан хамгаалах яаманд харьяалагддаг. 1ндэсний батлан хамгаалахын сайд нь 10-ийн төлөөлөгчөөр дамжуулан гамшгаас хамгаалах 1йл ажиллагааг удирддаг байна. 1ндэсний батлан хамгаалахын сайдын төлөөлөгч нь нийгэмлэгийг ерөнхий удирдлагаар хангах ба 1дүр тутмын ажлыг зохицуулан чиглүүлэх 1рэгтэй 1ндэсний батлан хамгаалахын сайдын төлөөлөгчийн туслах ажилладаг байна.


1ндэсний батлан хамгаалах яамны сайдын төлөөлөгчийн аппарат нь Төлөвлөлт бэлэн байдлын бодлогын газар, Мэргэжлийн газар, Олон нийт, мэдээлэл харилцааны газар, Удирдлага зохицуулалтын газартай байна.

Удирдлага зохицуулалтын газар нь төв орон нутгийн хэмжээнд гарсан гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээ 1зүүлэх, хор уршгийг арилгах ажиллагааг удирдлагаар хангаж байна.

Гамшгаас хамгаалах салбар дундын удирдлагын 1н1гийн байдалд хийсэн шинжилгээний 1рдүн:

Гамшгаас хамгаалах салбар дундын удирдлагын эрх з1йн баримт бичигт шинжилгээ хийхдээ Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд салбар дундын удирдлагатай холбоотой ямар заалт байгаа эсэхийн шинжлэн 1злээ.


Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны 1дрийн 150 дугаар тушаалаар “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын дундын байгууллагуудын харилцан ажиллагааг хэрхэн хангасан байдлыг шинжлэн 1злээ. Энэ төлөвлөгөө нь коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах удирдлагын баримт бичиг болж байна. Гамшгаас хамгаалах 1нд1рж1лсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн 1еийн хариу арга хэмжээний төлөвлөгөө нь хэрэгжүүлэх арга хэмжээ, Ц (хугацаа) цаг: минут, хариуцах байгууллага, хамтран ажиллах байгууллага гэсэн 4 хэсэгтэй, 22 байгууллагын оролцоотойгоор 30 хуудас материалаас 1рдэж байна. Хариу арга хэмжээний төлөвлөгөөнд харилцан ажиллагаатай холбогдсон асуудлын талаар алба салбар нь тэргүүлэх 1рэгтэй оролцсон байдлыг зураг 4-т 1зүүлэв.



С.Бямбас1рэн Гамшгаас хамгаалах улсын албадын харилцан ажиллагааг сайжруулах арга зам" УБ., 2021, 104 дахь тал

Гамшгаас хамгаалах салбар дундын удирдлага, зохицуулалтыг сайжруулах арга зам

Нэгдгээр бэлэгт гамшгаас хамгаалах удирдлагын ойлголт, мөн чанар, зохицуулалтын эрх зүйн ндэс, туршлага, сургамжийг судалсан байдал, хоёрдугаар бэлгийн 2.1 дэх дэд хэсэгт гамшгаас хамгаалах салбар дундын удирдлагын ннгийн байдалд хийсэн шинжилгээндээ тулгуурлан, цаашид сайжруулах арга замыг боловсрууллаа.



Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны Улсын хэмжээний болон салбар дундын зохицуулалтын удирдлагын бүтцийг зураг 5-т гаргалаа.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, өссөн цагийн байдалтай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэс нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн захиргааны болон төрийн бус олон нийтийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хангаж тэдгээрийн оролцоог уялдуулан зохицуулна.

Дүгнэлт

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд улсын болон орон нутгийн албыг гамшгаас хамгаалах ндсэн хич, хэрэгслээр томьёолж, тэдгээрийн зорилго, чиг үүргийг “Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах албаны ажиллах журам” зэрэг дүрэм, журам, зааварт тодорхой тусгасан байх шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 150 дугаар тушаалаар “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлвлөгөөнд салбарын дундын байгууллагуудын харилцан ажиллагааг хэрхэн хангасан байдлыг шинжлэн үзэхэд, хариу арга хэмжээний төлвлөгөөнд 177 арга хэмжээ тусгагдсанаас 51 заалт буюу 28.8 хувь нь харилцан ажиллагаатай холбогдсон заалт нэмэж тусгах шаардлагатай байна.

Гамшгаас хамгаалах арга хэмжээний зохион байгуулалт, удирдлага нь нутаг дэвсгэр-йлдвэрлэлийн зарчмаар аймаг нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн хэлбэр өл харгалзан зохион байгуулагдах нь оновчтой бөгөөд улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өөрөгтэй Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэгт онцгой байдлын газар, хэлтэс, албад, штаб, гал тиймэр унтраах аврах анги, салбартай байх чухал гэж үзэж байна.

Санал

Гамшгаас хамгаалах өөийн удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох арга замын талаарх санал:

1. Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах Улсын албадын хоорондын

удирдлага зохицуулалтыг хангах журмыг боловсруулан гаргаж ашиглах;

2. Гамшгаас хамгаалах тусгай ажиллагааны улсын хэмжээний салбар дундын зохицуулалтын удирдлагын бодлогыг 14 дүгээр зургаар гаргасны дагуу ашиглах;
3. Сангийн яам нь гамшгаас хамгаалах тусгай ажиллагаанд хөрөнгө мөнгийг шийдвэрлэхэд ихээхэн нөлөөтэй тул Гамшгаас хамгаалах Улсын албадын бодлогод "Санхүүгийн нөхцлийн удирдлагыг зохицуулах алба"-ыг оруулах саналыг тус тус дэвшүүлж байна.

Эх сурвалжийн жагсаалт:

Нэг. Эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Их Хурлын 2011оны 22 дугаар тогтоолоор Тамшгаас хамгаалах талаар тусгай баримтлах бодлого" баримт бичиг
2. Монгол Улсын Их Хурлын 2011оны 22 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр
3. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын хавсралтаар Гамшгаас хамгаалах талаар тусгай баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
4. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/, УБ., 2017

Хоёр. Сурах бичиг, гарын авлага

1. Эхнэсвэр: НБ-ын Гамшгийн аюулыг бууруулах олон улсын стратеги, нэр томьёо
2. НБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын "Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой нэр томьёо" 2009 (2009 оны 5 дугаар сар, Женев)

Гурав. Судалгааны ажлын тайлан

1. "Нутгийн удирдлагын нөхцлийн байдал, цаашдын зорилт" сэдэвт онол, практикийн хурлын илтгэл
2. Сэржмядаг Д., Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, УБ., 2017
3. Гамшгийн сэргээн босголтоос авсан сургамжууд
4. Дэлгэрэнгүй мэдээллийг Азийн гамшгийн бэлэн байдлын төвийн Азийн гамшгийн эрсдэлийн удирдлагын талаарх сурах бичгээс үзнэ үү (2005, хуудас 58-59, 165)
5. Дэлгэрэнгүй мэдээллийг НБ-ын ГАБОУСГ-ын "Эрсдэлтэй амьдрах нь" номоос (Азийн гамшгийн аюулыг бууруулах төв, 2001)

Дүрв. Цахим эх сурвалж

www.capetown.gov.za/eDocuments/Disaster